

**Петро Матад Лимитэд (“Петро Матад” эсвэл “Компани” гэх)
Үйл ажиллагааны талаархи шинэчилсэн мэдээлэл**

Петро Матад нь Монгол улсын зүүн хэсэгт байрлах өөрийн Матад ХХ талбайн нэг хэсэг болох Давсан толгойн хэтийн төлөв сайтай талбайн таамаг нөөцийн геологи, геофизикийн дүн шинжилгээнд дахин тайлал хийж дуусгалаа. Сейсмийн судалгааны дахин тайлалын үр дүнд Давсан толгойн хэтийн төлөв сайтай хэсгүүд болон түүний ойр орчмын талбайн (“Судалгааны Хэсэг” гэх) таамаг нөөц мэдэгдэхүйц хэмжээгээр нэмэгдсэнийг мэдэгдэхэд таатай байна. Судалгааны Хэсэг нь Матад ХХ талбайн зүүн хойд булангийн хэсэгт 365 км² талбайг хамарна.

Онцлох зүйлүүд

2010 онд Давсан Толгойн гүдэн бүтэц дээр амжилттай өрөмдсөн гурван цооногийн мэдээлэл болон түүний хэмжилтийн үр дүнг ашиглан Судалгааны Хэсэгт өмнө нь гүйцэтгэсэн 2 болон 3 хэмжээст сейсмийн ажлын үр дүнд дахин дүн шинжилгээг бид хийж гүйцэтгэлээ. Энэхүү дүн шинжилгээний онцлох зүйлүүд нь:

- Хэтийн төлөв сайтай талбай-18, хэтийн төлөв бүхий талбай-3 болж шинэчлэгдлээ.
- 2009 оны таамаг нөөцийн тооцоотой харьцуулбал Судалгааны Хэсгийн хэмжээнд хэтийн төлөв сайтай болон хэтийн төлөв бүхий талбайн таамаг нөөц нь эрсдэл тооцоогүй 275 сая баррель болон эрсдэл тооцсон 211 сая баррелиар тус тус нэмэгдсэн.
- Хураагуурын механизм болон агуулагч давхаргын шинж чанарын талаархи ойлголтыг ихээхэн дээшлүүллээ.
- Шинээр илрүүлсэн нэгж: Цагаанцавын Хамгийн дээд үе дэх нүүрсустөрөгч хуримтлуулах Давхаргазүйн систем
- Петро Матадын 2011 оны өрөмдлөгийн хөтөлбөрийг эдгээр үр дүнгүүдэд тулгуурлан боловсруулна

Дээрхи үр дүнгүүдийн талаар Петро Матадын Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даглас МакГэй хэлэхдээ “Давсан Толгойн Хэтийн Төлөв Сайтай талбайн таамаг нөөцийг шинээр тодорхойлсон нь бидний хувьд бас нэгэн амжилт юм. Манай мэргэжилтнүүд сейсмийн Судалгааны дахин тайлалыг хийхдээ өнгөрөгч онд амжилттай хийж дуусгасан өрөмдлөгийн мэдээллийг нарийн дэс дараатай, шилдэг аргачлалаар ашигласанд бид сэтгэл хангалуун байна. Шинээр тодорхойлсон Өвгөн голын эртний хөндийн хэтийн төлөв сайтай талбай нь үнэхээр сонирхол татахуйц талбай бөгөөд тус бүсийн хэмжээний таамаг нөөцийн шинэ бүрэлдэхүүн хэсэг болж байна. Дээрхи үнэлгээний үр дүн нь бидэнд 2011 онд Матад ХХ талбайн энэхүү хэсэгт өрөмдлөг болон хайгуулын ажлыг төлөвлөж, гүйцэтгэх үндэслэлийг бүрдүүлж өгөх юм. Түүнчлэн манай талбайн таамаг нөөц үнэлэхүйц хэмжээгээр нэмэгдсэнд бид баяртай байна” гэлээ.

Үйл ажиллагааны талаархи шинэчилсэн мэдээлэл

2010 онд Давсан Толгойн гүдэн бүтцийн дагуу гурван цооногийг амжилттай өрөмдөж дууссаны дараа цооногуудын мэдээлэл, хэмжилтийн үр дүнг өмнө нь Судалгааны Хэсэгт гүйцэтгэсэн 2 ба 3 хэмжээст сейсмийн судалгааны мэргэжлийн дахин үнэлгээнд

ашигласан. Нэмэлт мэдээллийг бид өрөмдөж дуусаагүй байгаа ДТ-4 цооног болон тухайн бүс нутагт өмнө нь өөр компаниудын гүйцэтгэсэн хайгуул, олборлолтын талаар хийсэн тандан судалгаанаас тус тус олж авсан. Доктор Жэймс Күүгэн болон Доктор Даваагийн Буян-Аривжих нарын удирдсан Компанийн техникийн багийнхан мэргэжлийн дахин үнэлгээг гүйцэтгэсэн болно.

Компанийн хэтийн төлөв сайтай 18 талбай болон хэтийн төлөв бүхий 3 талбай нь нүүрсустөрөгч хуримтлуулах гурван салангид системд хуваагдана. Судалгааны Хэсгийн хэмжээнд эрсдэл тооцоогүй олборлох боломжтой нийт таамаг нөөц нь 293 сая баррель, түүнээс эрсдэл тооцсон олборлох боломжтой нийт таамаг нөөц нь 225 сая баррель байна. Эрсдэл тооцоогүй олборлох боломжтой нийт таамаг нөөцийн хувьд энэ нь Давсан Толгойн хэтийн төлөв сайтай талбайнуудын өмнө нь тооцсон таамаг нөөцөөс ойролцоогоор гурав дахин их байгааг харуулж байна.

Судалгааны Хэсэг доторхи хэтийн төлөв бүхий талбай нь нэмэлт 145 сая баррелийн эрсдэл тооцоогүй, 45 сая баррелийн эрсдэл тооцсон олборлох боломжтой таамаг нөөцтэй.

Дээрхи магадлал бүхий таамаг нөөцийн хэмжээг Судалгааны Хэсгийн давхаргын хэмжээнд агуулагдаж буй 1.87 тэрбум баррелийн таамаг нөөцөөс тооцож гаргасан дүн болно. Судалгааны Хэсэг нь 137 км² талбайг хамрах 3 хэмжээст сейсмийн судалгааны талбайгаас бүрдэх бөгөөд тус талбайд өмнө нь мэдээлж байсан Давсан Толгойн гүдэн бүтэц дээрхи Хэтийн төлөв сайтай үндсэн талбай болон Баруун Давсан Толгой зэрэг жижиг хэмжээний гүдэн бүтцүүд багтана. Судалгааны Хэсгийн зүүн хэсэг нь янз бүрийн нягтралтай 2 хэмжээст сейсмийн торлолуудтай 228 км² талбайгаас бүрдэнэ.


Геологийн болон геофизикийн ажлуудад дахин дүн шинжилгээ хийсний үр дүнд бид Судалгааны Хэсгийн гүний бүтцийн нүүрсустөрөгч хуримтлуулах системийн чухал элементүүдийн талаар бүрэн ойлголттой болсон. Тус ажлын тусламжтайгаар бид хураагуурын механизм болон ДТ-1, ДТ-2, ДТ-3 цооногуудад хийсэн өрөмдлөг, бичиглэл, петрофизикийн болон дээжийн шинжилгээгээр тогтоогдсон тос агуулагч давхаргын шинж чанарын талаархи ойлголтоо улам сайжруулсан. Нүүрсустөрөгч хуримтлуулах системийн чухал элементүүдийн талаар бүрэн ойлголттой болсноор бид Матад ХХ талбай доторхи Судалгааны Хэсгийн хэмжээнд Компанийн хэтийн төлөв сайтай болон хэтийн төлөв бүхий талбайдын тоог шинэчлэн гаргах боломжтой болсон.

Хэтийн төлөв сайтай талбай нэмэгдсэн гол шалтгаан нь Дээд Цагаанцавын Нүүрсустөрөгч Хуримтлуулах Давхаргазүйн Систем хэмээн нэрлэгдсэн давхаргыг шинээр нээсэн явдал юм. Компани өмнө нь Давсан Толгойн Хэтийн Төлөв Сайтай Талбайн таамаг нөөцийг зөвхөн Дээд Цагаанцавын Нүүрсустөрөгч Хуримтлуулах Бүтцийн Системд тулгуурлаж гаргасан. Түүнчлэн Дээд Зүүнбаянгийн хэмээх нүүрсустөрөгч хуримтлуулах бүтцийн хураагуурийн систем шинээр нээсэн. Судалгааны Хэсэг нь дараахи системүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Доод Цагаанцавын Нүүрсустөрөгч Хуримтлуулах Бүтцийн Систем
- Цагаанцавын Хамгийн Дээд үе дэх Нүүрсустөрөгч Хуримтлуулах Давхаргазүйн Систем
- Дээд Зүүнбаянгийн Нүүрсустөрөгч Хуримтлуулах Бүтцийн Систем

Доорхи хүснэгтэнд Нүүрсүстөрөгч Хуримтлуулах Систем бүрийн хэтийн төлөв сайтай болон хэтийн төлөв бүхий талбайг үзүүлэв:

	Давхаргад агуулагдаж байгаа нийт тосны дундаж таамаг нөөц (сая баррелиар)\ STOIP (Stock tank oil initially in-place)	Олборлох боломжтой дундаж таамаг нөөц (Сая баррелиар)	Эрсдэл тооцсон олборлох боломжтой дундаж таамаг нөөц (Сая баррелиар)
ДООД ЦАГААНЦАВЫН ХЭТИЙН ТӨЛӨВ САЙТАЙ БҮТЦИЙН ТАЛБАЙ	529.1	119.1	71.5
ДООД ЦАГААНЦАВЫН ХЭТИЙН ТӨЛӨВ БҮХИЙ БҮТЦИЙН ТАЛБАЙ	90.7	20.4	3.6
ДЭЭД ЦАГААНЦАВЫН ХЭТИЙН ТӨЛӨВ САЙТАЙ ДАВХАРГАЗҮЙН ТАЛБАЙ	700.1	172.1	152.8
ДЭЭД ЦАГААНЦАВЫН ХЭТИЙН ТӨЛӨВ БҮХИЙ ДАВХАРГАЗҮЙН ТАЛБАЙ	550.5	124.6	41.1
ДЭЭД ЗҮҮНБАЯНГИЙН ХЭТИЙН ТӨЛӨВ САЙТАЙ ТАЛБАЙ		2.1 (P10)	



Зураг 1. Матад XX талбайн Давсан Толгойн хэсгээр нүүрсүстөрөгч хуримтлуулах систем болон хэтийн төлөв сайтай талбайдын тархсан байдал. Давсан Толгой дахь Доод Цагаанцавын нүүрсүстөрөгч хуримтлуулах бүтцийн системийн хэтийн төлөв сайтай талбайг хөх ягаан өнгөөр тэмдэглэв. Лаг Нуур орчмын Доод Цагаанцавын нүүрсүстөрөгч хуримтлуулах бүтцийн системийн хэтийн төлөв сайтай талбайг хөх өнгөөр тэмдэглэсэн. Ногоон өнгө нь Өвгөн голын эртний хөндийн Доод Цагаанцавын нүүрсүстөрөгч хуримтлуулах давхаргазүйн системийн хэтийн төлөв сайтай болон хэтийн төлөв бүхий талбай.

Доод Цагаанцавын нүүрсустөрөгч хуримтлуулах бүтцийн систем:

Доод Цагаанцавын бүтцийн нүүрсустөрөгч хуримтлуулах систем нь Давсан Толгойд анх тодорхойлсон нүүрсустөрөгч хуримтлуулах системийн талаархи ойлголт байлаа. Давсан Толгойн хэтийн төлөв сайтай талбайн чанх хойно залган орших Тосон Уул олборлолтын талбайн 100 сая баррель олборлох боломжтой нөөцийн тухай Петрочайна Дачин Тамсаг Монгол ХХК-ийн тайланд Доод Цагаанцавын Формаци нь тос агуулагч гол формациар тодорхойлогдсон.

Петро Матадын энэ удаагийн үнэлгээ нь зарим хуучин хэтийн төлөв сайтай талбай ба хэтийн төлөв бүхий талбайнуудыг хасч, бусдыг нь өөрчилсөн ба шинээр хэтийн төлөв сайтай болон хэтийн төлөв бүхий талбайнуудыг ялгасан. Судалгааны энэхүү хэсэгт нийт 119 сая баррель эрсдэл тооцоогүй олборлох боломжтой таамаг нөөц бүхий хэтийн төлөв сайтай Доод Цагаанцавын арван талбай байна.

Энэхүү хэсэг дэх Доод Цагаанцавын өмнөх хэтийн төлөв сайтай ба хэтийн төлөв бүхий талбайнуудад хийсэн өөрчлөлт нь маш сайн судлагдаж Доод Цагаанцавд байх боломжтой гэж өмнө нь үзэж байсан зарим хураагууруудыг хассан ба энэхүү шийдвэрийг 2010 оны өрөмдлөгийн үр дүнд тулгуурлан гаргасан. Гэвч ДТ-1, ДТ-2 ба ДТ-3 цооногуудын Цагаанцавын чулуулгаас илэрсэн хэмжигдэхүйц тосны ачаар өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэснээр үлдсэн хэтийн төлөв сайтай талбайдын тос үүсгэх, боловсрох, шилжих элементүүдийн эрсдлийг их хэмжээгээр бууруулсан.

Мөн давхаргазүй, гүн болон хагарлыг нарийвчлан тодорхойлсоноор тос хураах талбай ба тусгаарлагчтай холбоотой эрсдлийг бууруулж Доод Цагаанцавын нүүрсустөрөгч хуримтлуулах системийн Амжилтын Магадлал(POS)-ыг 60%-д хүргэсэн.


Дээрхи хэтийн төлөв сайтай 10 талбайг Монгол нэр томъёогоор нэрлэсэн бөгөөд бүгд “Давсан Толгой-гоор эхэлж, луужин дээрхи зүг чигийн нэршлүүдийг араас нь залгасан.

Тэдгээрээс, Давсан Толгой Шороо (Баруун Урд) хэтийн төлөв сайтай талбайд 4 дүгээр сард үргэлжлүүлэн өрөмдөхөөр төлөвлөөд байгаа ДТ-4 цооног оршино.

Судалгааны Хэсгийн зүүн талд орших хоёр шинэ хэтийн төлөв бүхий талбай нь Доод Цагаанцавын хэтийн төлөв бүхий талбайнуудад багтаж байгаа боловч 2009 онд хийгдсэн үнэлгээнд ороогүй байсан. Эдгээр хэтийн төлөв бүхий талбайнууд нь 18%-ийн Амжилтын Магадлалаар тооцоход 20.4 сая баррель эрсдэл тооцоогүй олборлох боломжтой таамаг нөөцтэй. Энэхүү талбайнуудыг ойролцоо орших Лаг Нуурын нэрээр нэрлэсэн болно.

Цагаанцавын хамгийн дээд үе дэх нүүрсустөрөгч хуримтлуулах давхаргазүйн систем


Цагаанцавын хамгийн дээд үе дэх нүүрсустөрөгч хуримтлуулах Давхаргазүйн систем нь ДТ-1 ба ДТ-2 цооногийн өрөмдлөгийн үр дүн болон Дачингийн Тосон Уул XIX талбайн урд хэсэгт явагдаж байгаа олборлолтоор нотлогдсон ойлголт юм. Цагаанцавын хамгийн дээд үе дэх тос агуулагч давхарга нь ДТ-1 ба ДТ-2 цооногуудыг 3 хэмжээст ба 2 хэмжээст сейсмийн зураглалын үргэлжилсэн 100 км² гүний гадаргын зурагтай уялдуулан ялгасан шинэ нэгж юм. Мөн 3 хэмжээст сейсмийн талбайд 1-2 км² хэтийн төлөв сайтай жижиг талбай, 2 хэмжээст сейсмээс 70км² хэтийн төлөв бүхий талбайг Давсан Толгойн зүүн талд ялгасан.



Зураг 2. Цагаанцавын хамгийн дээд талын үеийн нүүрсустөрөгч хуримтлуулах давхаргазүйн системийг тодорхойлж буй эртний хөндийн системийн сейсмийн дүрслэлийг харуулсан Давсан Толгойн 3 хэмжээст сейсмийн судалгаанаас авсан сейсмийн зүсэлт

Энэхүү Цагаанцавын хамгийн дээд үеийн давхаргазүйн дараалал нь доор нь орших Дээд ба Доод Цагаанцавын давхаргадасууд руу элэгдэж орсон 240м хүртэл зузаан давхаргазүйн гадаргуу бүхий эртний хөндий юм. ДТ-1 ба ДТ-2 цооногуудад тэмдэглэгдсэн бүдүүн ширхэгтэй элсэн чулуулаг болон 19-62 цооногоос хийж байгаа эдийн засгийн үр ашигтай олборлолтоос таамаглаж болох агуулах давхрагын чанар нь энэхүү хөндийг дүүргэсэн хурдас нь элс давамгайлсан байж болохыг харуулж байна. Энэ нь Доод Зүүнбаянгийн занарын доод хэсэгт байх бүсийн үл нийцлээр хучигдан тэр хэсэгтээ таслагдсан байна.

Энэхүү дарааллын зураглал нь тус эртний хөндийн системийн голууд нь Давсан Толгойн гүдэн бүтцийн оройгоос хойд ба зүүн зүг рүү урссаныг харуулж байна. 2 хэмжээст сейсмийн тайлалаар эртний хөндийн их бие нь Дачингийн Тосон Уул XIX талбайн 19-62 дугаарт олборлолтын хэсэгтэй шууд холбогдож байгаа нь чухал. Петро Матадын хээрийн ажиглалт болон орон нутгийн хээрийн ажилчид Дачингийн 19-62 цооног 2006 оны сүүлээс 2009 оны сүүл хүртэл тасралтгүй олборлолт явуулж байгаа нотолж байгаа.




Зураг 3. Цагаанцавын Формацийн оройн хэсгийн түвшин (бор өнгийн шугамууд), түүний доор орших Цагаанцавын хамгийн дээд хэсгийн эртний голын хөндийн хурдсын нийт зузаан болон тархалт (өнгөөр). Цэнхэр өнгийн шугам болон сумаар эртний голын хөндийн урсгалын чиглэлийг тэмдэглэсэн.

19-62 цооногийн таамаг ус тосны заагаас дээш, Матад ХХ талбайн хил доторх 93 км² талбайг эзлэх Цагаанцавын хамгийн дээд үе дэх нүүрсустөрөгч хуримтлуулах Давхаргазүйн системийн хэтийн төлөв сайтай төв талбайг Өвгөн Гол гэж нэрлэсэн. Өвгөн Голын эрсдэл тооцоогүй олборлох боломжтой таамаг нөөцийн тооцоо нь 165 сая баррель. ДТ-1 ба ДТ-2 цооногийн тосны илрэл, нүүрсустөрөгчийн ханалтын болон нүх сүвшилтийн өндөр үзүүлэлтүүд болон 19-62 цооногийн олборлолт нь Амжилтын Магадлал 90% буюу өндөр байхын шалтгаан болж байна.

3 хэмжээст сейсмийн судалгааны талбайд жижиг эртний хөндий хоёр тогтоогдсон бөгөөд хэтийн төлөв сайтай талбай болоход хангалттай судлагдсан. Баруун урд Өвгөн Гол ба Баруун хойд Өвгөн Гол нь нийлээд 60%-ийн Амжилтын Магадлалаар эрсдэл тооцоогүй олборлох боломжтой 7.1 сая баррель тосны таамаг нөөцтэй.


Түүнчлэн энэхүү нүүрсустөрөгч хуримтлуулах систем нь Судалгааны Хэсгийн зүүн хэсэгт байрлах 2 хэмжээст сейсмээр тодорхойлогдсон 70 км² талбайг хамарсан Зүүн Өвгөн Гол хэмээх хэтийн төлөв бүхий томоохон талбайтай. Тус хэтийн төлөв бүхий талбай нь 33%-ийн Амжилтын Магадлалаар эрсдэл тооцоогүй олборлох боломжтой 125 сая баррель тосны таамаг нөөцтэй.



Зураг 4. XIX дүгээр талбайн олборлолт явуулж буй 19-62 дугаар хэсгийн орчмын 2 хэмжээст сейсмийн зүсэлтийн зураг. Доор нь орших Доод Цагаанцавын Формац руу элэгдэж орсон Цагаанцавын хамгийн дээд талын эртний хөндийн системийг харуулсан. Эртний хөндийн системийн суурь хэсэг нь голдирлын хэлбэр болон Доод Цагаанцавын Формацийн сейсмийн зүсэлт дээрхи ойлтын тасалдалаас тодорхой харагдана.

Дээд Зүүнбаянгийн нүүрсүстөрөгч хуримтлуулах бүтцийн систем

Цэрдийн насны Дээд Зүүнбаянгийн Формаци нь Матад ХХ талбайн хайгуулын ажлын хоёрдахь зорилго юм. Энэ нь Тосон Уулын ордын хойд хэсэгт мэдэгдэж байгаа олборлолтын давхаргадас юм. ДТ-3 цооногийн тосны илрэл ба олборлолтынх байх боломжтой гэж тооцоолсон давхаргадас, мөн ДТ-1 ба ДТ-2 цооногуудад гарсан хураагуурын ойролцоо байх магадлалтай гэсэн шинж тэмдэгүүдийн зэрэгцээх бүтцийн зураглал нь эдгээр талбайнууд дөрвөн талаасаа хаагдсан гүдэн бүтцийн хажууд байна гэдгийг илтгэж байна. Эрсдэл тооцоогүй Р10-аар 2.1 сая баррель тосны таамаг нөөцтэй дөрвөн талаасаа хаагдсан 5 жижиг гүдэн бүтэц тодорхойлогдсон. Бусад (хагарлын ба давхаргазүйн) хураагуурын төрлүүд цаашдын хайгуулын явцад таарах магадлалтай.



Зураг 5. Дээд Зүүнбаянгийн Формацийн ёроолын хэсгийн гүний түвшинг харуулсан зураг. Тодруулсан хэсгүүд нь DT-3 цооногийн ойролцоо тогтоогдсон хураагуур бүхий дөрвөн талаасаа хаагдсан гүдэн бүтцүүдийг.

Дээрхи мэдээлэл нь зураг, диаграм, техникийн нэмэлт мэдээллийн хамт Компанийн цахим хуудас www.petromatad.com дээр тавигдана.

Энэхүү шинэчилсэн мэдээлэлд агуулагдсан техникийн хэсгийг Компанийн Хайгуулын Менежер Доктор Жеймс Күүган хянасан болно. Доктор Күүган нь Хойд Америк, олон улсын хайгуулын болон ашиглалтын чиглэлээр 29 жил ажилласан туршлагатай газрын тосны геологич юм. Тэрээр Америкийн Газрын тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн юм.

Энэхүү мэдэгдлийн таамаг нөөцтэй холбоотой бүх мэдээллийг Газрын Тосны Геологичдын Холбооноос (“ГТГХ” гэх) баталсан Газрын Тосны Нөөцийн Менежментийн Систем-2007 (“ГТНМС” гэх)-д заасан нэр томъёоны тодорхойлолт, удирдамжид заасны дагуу боловсруулав. Таамаг нөөцийн нийт дүнг ГТГХ 2007

ГТНМС-д заасан удирдамжийн дагуу арифметикийн аргаар тооцож гаргав. Тиймээс эдгээр нийт дүнд статистик бүхэлдүүлэлтээс үүсэх портфель нөлөөг тооцохгүй.

Петро Матад Лимитед компанийн тухай

Петро Матад нь Монгол Улсад газрын тосны хайгуул хийх, цаашид ашиглалт, үйлдвэрлэл явуулах зорилго бүхий группын толгой компани юм. Тус групп нь Монгол Улсын Засгийн газартай Бүтээгдэхүүн Хуваах гурван гэрээг дангаар байгуулан ажиллаж байна. Группын үндсэн хөрөнгө нь Монгол орны зүүн хэсэгт орших 10,340 км² талбай бүхий газрын тосны Матад ХХ талбайн Бүтээгдэхүүн Хуваах Гэрээ (“БХГ” гэх) юм. Үлдсэн хоёр талбай болох IV ба V талбайд нь Монгол орны төв хэсэгт оршдог бөгөөд хоёр талбай нийтдээ 71,040 км² талбайг хамарна.

Нэмэлт мэдээллийг:

Петро Матад Лимитэд
Ерөнхий Гүйцэтгэх Захирал - Даглас Жэй МакГэй (Douglas J. McGay)
+976 11 331099

Уэстхауз Секьюритиз Лимитэд
Ричард Бэти/Питр Нортон (Richard Baty/Petre Norton)
+44 (0)20 7601 6100

Товчлол ба геологи, техникийн нэр томъёо

Товчлол	Тодорхойлолт
2 хэмжээст	Хоёр хэмжээст
3 хэмжээст	Гурван хэмжээст
Тэрбум баррель	Тэрбум баррель /АНУ-ын хэмжээгээр/ Баррель /АНУ-ын хэмжээгээр/
Тос хураах талбай	Хураагуурын хүрээ доторхи талбай. Хураагуурын хүрээ доторхи талбай болон гүдэн бүтцийн өндрийг хураагуурт агуулагдаж буй нүүрсустөрөгчийн хэмжээг тооцоход ашиглана.
Км	Хавтгай дөрвөлжин километр
Хэтийн төлөв бүхий талбай	Өрөмдлөг хийхэд хангалттай боловсроогүй нүүрсустөрөгчийн боломжит хураагуур. Нэмэлт судалгаа, мэдээллийн тусламжтайгаар хэтийн төлөв бүхий талбай нь хэтийн төлөв сайтай талбай болно. Өөрөөр хэлбэл сейсмийн торлолын нягтрал багатай талбай.
Дундаж	Хэд хэдэн утгуудын арифметик дундаж

Сая баррель	Сая баррель /АНУ-ын хэмжээгээр/
P10/Пи10	Хэтийн төлөв сайтай талбайгаас тос илрүүлэх магадлал 10%-иас дээш байх ёстой
Эртний хөндийн систем	тунамал чулуулгаар дүүргэсэн доод давхаргын чулуулаг руу элэгдэж орсон эртний хөндий
Нүүрсустөрөгч Хуримтлуулах Систем	Нүүрсустөрөгчийг барьж тогтоож буй хураагуурын төрлүүд
POS	Амжилтын магадлал
Хэтийн төлөв сайтай талбай	Өрөмдлөгийн цэг тодорхойлох боломжтой болтол сайн судлагдсан боломжит хуримтлал бүхий талбай
Магадлал бүхий таамаг нөөц	Газрын Тосны Инженерүүдийн Нийгэмлэг, Дэлхийн Газрын Тосны Консул болон Америкийн Газрын Тосны Геологичдын Ассоциацийн тодорхойлсоноор нээгдээгүй байгаа хуримтлалаас тухайн нөхцөлд олборлох боломжтой гэж тодорхойлсон газрын тосны хэмжээг хэлнэ.
Таамаг нөөц	тухайн үеийн эдийн засгийн болон үйл ажиллагааны нөхцөл байдалд эдийн засгийн үр ашигтайгаар олборлох боломжтой гэж үзэж тооцоолон гаргасан нээгдээд байгаа газрын тосны хуримтлалын хэмжээг хэлнэ
Сейсмийн судалгаа	хуурай газар болон далайд дууны долгион илгээж гүнд байгаа чулуулагийн гадаргуугаас ойсон долгионыг бичиж аван гүний бүтцийн зураглал хийх боломжтой болгох геологийн аргачлал
Давхаргад агуулагдаж буй нийт тос	stock tank oil initially in-place
Давхаргазүй	чулуулагийн давхрагыг судладаг шинжлэх ухаан. Давхрагуудын анхдагч дараалал, тэдний хасны уялдаа, хэлбэр, тархац, литологийн найрлага, эртний амьтадын үлдэгдэлийн агууламж, геофизик ба геохимийн шинж чанар, тэдгээрийн орчны тайлал, үүслийн төрөл, геологийн түүх
Хураагуур	тос ба хийн дээшээ чиглэсэн хөдөлгөөнийг барьж аль нэгийг эсвэл хоёуланг нь хуримтлуулах саадыг хэлнэ. үүнд: агуулагч чулуулаг болон дээр нь байх эсвэл дээшээ налуу үл нэвчүүлэх таглаа чулуулагууд орно